

## АТАР-ӨРГӨӨ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Улс, нийслэлийн Онцгой комисс, эрүүл мэнд, мэргэжлийн хяналтын байгууллагаас тавьж буй шаардлага, өгч байгаа зөвлөмж, Атар-Өргөө ХК-д тогтоосон дэглэмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирж байгаа хувьцаа эзэмшигчдийг амны хаалттай оруулж, гарын ариутгал хийлгэж, биеийн халууныг үзэх үүргийг хурал зохион байгуулах комиссын гишүүн И.Артём гүйцэтгэв.

Хурал зохион байгуулах комиссын гишүүд, Тооллогын комиссын гишүүд, хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийг тус тусад нь байрлуулсан ширээнд 1.5-2 метрийн зайнд суулгаж, хурлын үйл ажиллагааны явцад байнгын амны хаалттай байх, саналын хуудас болон бусад баримт бичиг өгч авалцах, хурал дууссаны дараа гарын ариутгал хийж, хурлын танхимаас шууд гарч явах, хурлын үйл ажиллагааны явцад болон хурлын танхимаас гарч явах үед бусадтай уулзах, биеэр харилцахгүй байхыг хурал даргалагч анхааруулж зөвлөгөө өгөв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 27-ны 10:16 цагт Атар-Өргөө ХК-ийн 2 дугаар давхрын хурын танхимд эхлэв.

Хурлыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Мөнхдалай даргалж, хурлын нарийн бичгийн даргын хэсэгт Ц.Доржготов, И.Артём нар, Тооллогын комисст, Ч.Жадамба, Э.Түвшинбаяр, Ц.Энхтүвшин нар тус тус ажиллав.

Тус хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн С.Бямбахорлоо, Ц.Галтаа, Б.Даваахүү нар оролцов.

Хурлын дарга **Б.Мөнхдалай**: Хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн бүртгэл, хурлын ирцийн талаар Тооллогын комиссыг мэдээлэл өгөхийг хүсэв.

Тооллогын комиссын дарга **Ч.Жадамба**: Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 174,136 ширхэг буюу 1,567,224 саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшдэг 343 хувьцаа эзэмшигчид оролцохоос 88,024 ширхэг буюу 792,216 саналын эрхтэй 5 хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр болон итгэмжлэлээр оролцохоор хүрэлцэн ирсэн нь нийт саналын эрхийн 50.54 хувь болж байгааг мэдэгдэж, хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны 01 дүгээр тогтоолыг уншиж танилцуулав. (Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав)

**Б.Мөнхдалай:** Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хурал маань зохих дэгийн дагуу явагдана. Хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг хувьцаа эзэмшигчдэд урьдчилан хүргүүлж, танилцуулсан тул хурлаар хэлэлцэх асуудлын дэгээ батлах санал оруулж байна. Саналаа гаргана уу.

Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдээс төлөвлөж оруулсан хурлын дэгд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаагүй тул хурлын дэгээ баталъя. Баталъя гэсэн шийдэл дээр гараа өргөцгөөе. За 100 хувийн саналаар баталлаа.

Хурлын дэгийн дагуу Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлт, Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдохоор нэр дэвшсэн нэр дэвшигчдийн тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийн төслийн тухай танилцуулга, мэдээллийг хурлын дарга Б.Мөнхдалай нэг бүрдчилэн танилцуулав. (Хурлаар хэлэлцсэн асуудлын танилцуулга, мэдээллийг хавсаргав)

**Хувьцаа эзэмшигч Б.Ганбат:** Хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудын талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал, санхүүгийн төлөөлөлтэй уулзаж ярилцаж, зохих мэдээлэл авч, санал бодлоо илэрхийлж байсан тул асуух асуулт байхгүй байна. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн олонх нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгуульт үүрэг гүйцэтгэж, хурлаар хэлэлцэх асуудлын талаар өмнө нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар ярилцаж шийдвэрлэсэн. Иймд хурлаас гарах шийдвэрийн төслийг батлах санал гаргаж байна.

**Б.Мөнхдалай:** Асуулт асуух, санал гаргах өөр хувьцаа эзэмшигч байна уу. Асуулт асуух, санал гаргах өөр хувьцаа эзэмшигч байхгүй бол асуулт, санал гаргах асуудлыг дуусгах уу. Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид дуусгая гэсэн саналаа илэрхийлэв.

**Б.Мөнхдалай:** Хурлаар хэлэлцэх асуудал хурлын дэгийн дагуу явагдаж дууслаа. Та бүхэн хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар саналаа өгч, саналын

хуудсаа Тооллогын комисст хураалгаарай. Одоо Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авч, тооллого хийж, дүнг танилцуулах ажилдаа орёё. Тооллогын дүн гартал хурлын ажиллагааг түр завсарлуулъя гэснээр хурал завсарлав.

**Б.Мөнхдалай:** Тооллогын комиссын ажил дуусч тооллогын дүн гарсан байна. Тооллогын комиссын дарга Ч.Жадамба Та дүнгээ танилцуулна уу.

**Тооллогын комиссын дарга Ч.Жадамба:** Тооллогын комисс Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд өөрийн биеэр болон итгэмжлэлээр оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал өгсөн саналын эрхийг тоолж, дүнг нэгтгэж гаргалаа. Тооллогын комисст нийт 5 ширхэг саналын хуудас хүлээлгэн өгснөөс 5 саналын хуудсыг хүчинтэй тооцсон. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

Тооллогын дүн (ердийн аргаар санал өгсөн)-ээр Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлахыг, Компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг зөвшөөрөхийг, Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрөхийг, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийн төслийг батлахыг хуралд оролцож байгаа 88,024 саналын эрхийн 100 хувийн саналаар батлах санал гаргасан, тэдгээр асуудлаар татгалзсан, түдгэлзсэн санал гараагүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгсөн саналын эрхийг тоолоход ердийн гишүүнд нэр дэвшигч Б.Мөнхдалайг 88,024, Б.Ганбатыг 88,024, Ж.Сайнбилэгийг 88,024, Г.Баттулгыг 88,024, Г.Энхболдыг 88,024, М.Мөнхтэнгисийг 88,024 саналын эрхээр сонгох санал өгч, ердийн гишүүнээр нэр дэвшигч Д.Даваадорж, Б.Даваахүү нарт санал өгөөгүй, хараат бус гишүүнд нэр дэвшигч С.Бямбахорлоог 88,024, Л.Бямбажаргалыг 88,024, Б.Бадамжаргалыг 88,024 саналын эрхээр сонгох санал өгч, хараат бус гишүүнд нэр дэвшигч Ц.Галтаа, Н.Доржсүрэн нарт санал өгөөгүй болохыг тус тус танилцуулаад “Саналын хуудсаар санал өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүнгийн тухай” Тооллогын комиссын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг уншиж сонгов. (Тогтоолыг хавсаргав)

**Б.Мөнхдалай:** Тооллогын комиссын шийдвэрийн талаар асуух асуулт байна уу. Асуулт гарсангүй. Асуулт байхгүй бол Тооллогын комиссын шийдвэрийг батлах саналтай хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү, бүгд гараа өргөсөн тул Тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталлаа.

**Б.Мөнхдалай:** Хурал хэлэлцэх асуудлуудыг дэгийн дагуу явуулж дууссаныг мэдэгдэж, хувьцаа зээмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл (Тооллогын комиссын тогтоолыг батлах тухай, Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай, Аудитын дүгнэлтийг зөвшөөрөх тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрөх тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг баталж, бүрэн эрхийг зөвшөөрөх тухай, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалингийн хэмжээ болон дотоод ажлын зардлын төсвийг батлах тухай, Сонгуульт ажлаас чөлөөлөх тухай)-ийн төслүүдийг уншиж сонсгов.

Хурлаар хэлэлцэх асуудал 11:52 цагт дууссан тул хурал хаасныг мэдэгдэв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХАТГАЛСОН:

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Ц.ДОРЖГОТОВ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИДСАН

ХУРЛЫН ДАРГА 

Б.МӨНХДАЛАЙ